

Байгууллагын нэр: "Амгалан Дулааны Станц" ХХК

Химийн хэсэг
ААД-н шалгалтын асуултын мэдээлэл

2018-09-01

№	Асуулт	Сонголтын тоо	Хариулт 1	Хариулт 2	Хариулт 3	Хариулт 4	Хариулт 5
1	Төмөр шатыг барих үед түүнээс хэдэн метрээс бага зайд байгаа цахилгаан дамжуулах шугамын гүйдлийг таслах, газардуулах, утасны галуур бүрхүүл хийх, буулгаж зайлуулах вэ?	3	4м	5м	6м	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
2	Наряд олгох эрх бүхий хүмүүсийн нэрсийн жагсаалтыг ямар хугацаанд шинэчилсэн гаргаж хэн батлах вэ?	3	6 сар тутамд үйлдвэрийн ерөнхий инженер батлаж жагсаалтын хуулбарыг ээлжийн дарга, ДИС-н өрөөнд тавина.	12-р сард цехийн дарга баталж хуулбарыг ДИС-н өрөөнд тавина.	Жил бүр үйлдвэрийн ерөнхий инженер батлаж жагсаалтын хуулбарыг ээлжийн дарга, ДИС-н өрөөнд тавина.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
3	Хэдэн метрээс өндөр шатыг акт бүрдүүлж, комиссоор хүлээн авсны дараа ашиглахыг зөвшөөрдөг вэ?	3	3м	4м	5м	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
4	Шаталт гэж юуг хэлэх вэ?	3	Хүний эрүүл мэндэд аюултай хий үүсгэдэг процесс.	Ихээхэн гэрэл, дулаан ялгаруулан хоромхон зуур явагддаг химийн исэлдэх урвал.	Дулаан ялгаруулдаг гинжин урвал.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
5	Ажлын байран дахь галын аюулгүй байдлыг аль албан тушаалтан нар хариуцах вэ?	3	Галын аюулгүй байдлыг хариуцсан ажилтан хариуцана.	Тухайн ажлын байранд ажилладаг ажилтан хариуцана.	Галын сайн дурын бүлгэмийн ахлагч хариуцана.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
6	Зөөврийн цахилгаан гэрэлтүүлэг нь хэдэн В-с хэтрэхгүй байх ёстой вэ?	3	36 В	220 В	12 В	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
7	Тусламж үзүүлэгч бүх насны өвчтөнүүдэд амилуулах суурь тусламжийг хийхдээ цээж шахах, амьсгалуулах үйлдлийн хоорондын харьцаа хэд байх вэ?	4	5 шахалт даралт 1 амьсгалуулалт	30 шахалт 2 амьсгалуулалт	10 шахалт 2 амьсгалуулалт	15 шахалт 1 амьсгалуулалт	Сонголт байхгүй
8	Шатдаг бодис, материал гэж юу вэ?	3	Галын эх үүсвэрийг ойртуулахад дөллөж асдаг бодис, материал.	Ердийн нөхцөлд галын эх үүсвэрийг ойртуулахад асаж, холдуулахад унтарч шатдаггүй бодис, материал.	Ердийн нөхцөлд галын эх үүсвэрийг ойртуулахад асаж, холдуулахад өөрөө бие даан шатах чалвартай бодис, материал.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
9	Нярадаар ажил гүйцэтгэх үед/ажилд байгаа тоноглолын аюултай зайд ажилчидыг ойртуулахгүй байлгах тавигдсан хаалт хашилт санамж тэмдэгүүдийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж бригадын гишүүдийн аюулгүй ажиллагаанд/нөлөөлж байгаа эсэхэд хэн хяналт тавих вэ?	3	Ажиглагч	Бригадын бүх гишүүд	Ажил гүйцэтгэгч	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
10	Хэдэн хэмийн халуун агаартай хэсэгт засварын ажлыг хийх үед зөөврийн агаарын салхилуурын төхөөрөмжийг ашиглах вэ?	3	30С	33С	350С	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

11	Үйлдвэрийн нэгж, гүйцэтгэгч байгууллагаас үндсэн тоноглолын наряд ба ам шийдвэрээр ажил гүйцэтгэгчийг томилоход мэргэжлийн хэддүгээр зэрэгтэй хүн томилох вэ?	3	III-р зэрэгтэй хүн	IV-р зэрэгтэй хүн	Дээд боловсролтой	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
12	1000 В хүртэл хүчдэлтэй дамжуулах утас, гүйдэл дамжуулах хэсгээс нэрвэгдэгчийг чөлөөлөхийн тулд ямар материал зүйлсийг ашиглах вэ?	3	Цахилгаан гүйдэл дамжуулахгүй материал	Хувцаснаас татаж салгана	Олс, саваа, банз буюу гүйдэл дамжуулахгүй зүйлс ба хуурай зүйлс ашиглана	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
13	Дүүжин ба зөөврийн шатыг өргөх буулгахад хэрэглэж байгаа суурин дээр бэхлэх боломжгүй үед ажлын даацаас хэд дахин их ачаагаар даруулж тогтвортой байдлыг хангах вэ?	3	1.25 дахин	1.5 дахин	2 дахин	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
14	Бригадын гишүүдийн хүлээх хариушлага	3	Хамгаалах хэрэгсэл ажлын хувцасыг бүрэн хэрэглэж ашиглагдаж байгаа багаж хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж байгаа эсэх, ажил гүйцэтгэх үеийн аюулгүйн нөхцөл, шаардлагыг мөрдөж байгаа эсэхэд	Ажлын байр зөв эсэхэд	Ажлын байранд тавигдсан хаалт, хашилт, аюулгүйн тэмдэгүүд, хориглох, түгжих байгууламжууд бүрэн байгаа эсэхэд	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
15	Ухаангүй өвчтний амьсгалын зам бөглөрөх хамгийн түгээмэл шалтгаан юу вэ?	4	Аман доторх зүйл	Хэл	Зоос	Хиймэл шүд	Сонголт байхгүй
16	Нооцлох саван дотор ажиллагч аврах ослыг 3 удаа татвал ажиллагчид өгсөн ямар дохио вэ?	3	Олсыг суларуул	Хэвийн байна	Гаргаж ав	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
17	I.Техникийн усан аммиакийн нягт хэд вэ? /150С-д/	3	0,5 г/см3	0,5кг/м3	0.9 г/см3	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
18	Аммиактай ажиллах үед ямар хувийн хамгаалах хэрэгслүүдийг хэрэглэдэг вэ? 1.Хүчил, шүлтэнд тэсвэртэй резинэн бээлий 2.Нүдний хамгаалах шил 3.Резинжүүлсэн хормогч 4.Шүүгч хорт утааны баг 5. КД маягийн хорт утааны баг	4	1,2,3,4	1,2,3,5	3,4,5	Бүгд	Сонголт байхгүй
19	Хэрэв хувцсан дээр хүчил асгарвал хэдэн хувийн ямар уусмалаар саармагжуулах вэ?	3	2-3%-н содын уусмалаар саармагжуулж, их хэмжээний усаар угаана	5%-н содын уусмалаар саармагжуулж, усаар зайлна.	2-3% -н содын уусмалаар саармагжуулж, их усаар угааж дахин усаар зайлна.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
20	Химийн цэвэр давсны хүчлийн нягт хэд вэ?	3	1,09 мг/см3	1,1-1,2 мг/см3	1,19 мг/см3	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
21	Түлэгдэх үед арьс цэврүүлэхийг хэддүгээр зэргийн түлэгдэлтэнд хамруулах вэ?	3	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

22	Нарядгүйгээр гүйцэтгэх ажилд ам шийдвэрээр өгөх эрхийг ямар хүмүүс олгох вэ?	3	Ээлжийн инженер	Наряд олгох эрх бүхий хүмүүс	Цехийн ашиглалтын инженер	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
23	Түлэгдэлтийг юу юу гэж ангилдаг вэ? 1. Дулааны түлэгдэлт 2. Химийн түлэгдэлт 3. Усны түлэгдэлт 4. Цахилгааны түлэгдэлт	4	1,3,4	1,2,4	2,3,4	Бүгд	Сонголт байхгүй
24	Хийгээр хордох болон хордлогын бүх тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ? 1. Нэрвэгдэгчийг хордсон бүсээс яаралтай гаргах 2. Амьсгалахад саад болж байгаа хувцасны товчийг тайлна 3. Цэвэр агаар амьсгалах боломжийг олгоно 4. Хөлийг өндөрлөн хэвтүүлнэ 5. Дулаан хучина 6. Наштырийн спирт үнэртүүлнэ.	4	1,2,4,5	1,3,4,5,6	3,4,5,6	Бүгд	Сонголт байхгүй
25	Хүний биенд хатуу байдалтай хүүхрийн хүчил, шүлт орвол ямар арга хэмжээ авах вэ?	3	Хуурай хөвөн материалаар арчиж зайлуулсны дараа түлэгдсэн газрыг усаар сайтар угаана	Хатуу байдалтай химийн бодисыг усаар сайтар угааж , зайлуулсны дараа арчиж цэвэрлэнэ	Хатуу байдалтай химийн бодисыг усаар сайтар угааж зайлуулсны дараа түлэгдсэн газрыг усаар сайтар угаана	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
26	Анхны тусламжийн эмийн санд уудаг сод хэдэн гр байх ёстой вэ?	4	20гр	25гр	45гр	50гр	Сонголт байхгүй
27	Үйлдвэрлэлийн ажлын байрны шуугианы хэмжээ 20 ДБ-с дээш байвал эрүүл мэндийн үзлэгт ямар хугацаанд хамрагдах вэ?	3	12 сард 1 удаа	24 сард 1 удаа	36 сард 1 удаа	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
28	Химийн түлэгдэлтийн үед арьсны түлэгдэлтийн гүн хугацаанаас яаж хамаарах вэ?	3	Урвуу хамааралтай	Ямар ч хамааралгүй	Шууд хамраалтай	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
29	Нүүрсхүчлийн хий нь ямар хортой үйлчилгээ үзүүлдэг вэ?	3	Агаарт хуримтлагдвал тэсрэх аюултай	Агаарын хүчилтөрөгчтэй холилдож амьсгаа боогдуулна.	Унтуулах үйлчилгээтэй ба салст бүрхүүлийг цочроодог	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
30	Техникийн давсны хүчил ямар шинж чанартай, хэдэн хувийн хлорт устөрөгч агуулдаг вэ?	3	Өнгөгүй , агаарт утаа гаргадаг, 37%-н хлорт устөрөгч агуулдаг	Хар хүрэн өнгөтэй, утаа гаргадаггүй, амьсгал давхцуулах үнэртэй, 25 %-н хлорт устөрөгч агуулдаг	Шар өнгөтэй, амьсгал давхцуулах үнэртэй, 27,5 %-н хлорт устөрөгч агуулдаг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
31	Устөрөгчийн хэт ислийн нягт, түүний шинж чанар	3	1,45г/см3 нягттай, өнгөгүй, шүүслэг шингэн	1,45г/см3 нягттай, шаргал өнгөтэй, шүүслэг шингэн	1,35 г/см3 нягттай, өнгөгүй, шүүслэг шингэн	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
32	Хими лаборатори нь албадлагын салхижуулалттай сорох шүүгээгээр тоноглогдсон байх ба шүүгээний хаалгаар сорогдох агаарын урсгалын хурд хэд байх вэ?	3	0,5-0,8м/с	0,5-0,7м/с	0,8-1,0м/с	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

33	Аммиакын ажлын байрны агаарын орчин дахь хорт бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, хорын ангилал хэд вэ?	3	20 мг/м3, бага хортой	15-28 мг/м3, бага хортой	20 г/м3, бага хортой	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
34	Хүчилтөрөгч нь ямар хортой үйлчилгээ үзүүлдэг вэ?	3	Нүд ба амьсгалын замыг цочруулах, амьсгал боогдуулах	Ихэнх бодистой холилдож амьсгаа боогдуулна.	Хортой үйлчилгээгүй боловч цэвэр хүчилтөрөгч (атмосферын даралтанд) – өөр удаан амьсгалбал уушигны хальс хөөж үхэлд хүргэнэ	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
35	Ацетилен, угаарын ба байгалийн хий, бензолын уур зэргээр хордоход ямар шинж тэмдэг илэрдэг вэ? 1. Толгой өвдөх 2. Чих шуугин шанаагаар өвдөх 3. Бүх бие сулрах, толгой эргэх 4. Дотор муухайрч бөөлжис цутгах 5. Бөөлжих, зүрх хүчтэй цохих	4	1,2,3	2,3,4,5	3,4,5	Бүгд	Сонголт байхгүй
36	Аммиак нь ямар хортой үйлчилгээ үзүүлдэг вэ?	3	Нүд ба амьсгалын замыг цочруулах, амьсгал боогдуулах	Агаарын хүчилтөрөгчтэй холилдож амьсгаа боогдуулна.	Хүний уушигийг хөргөж ухаан алдуулах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
37	Хүчил устай ямар ч харьцаагаар урвалд орох ба хүүхрийн хүчлийн нэг мольд хэчнээн хэмжээний дулаан ялгаруулдаг вэ?	3	92 КДж	95 КДж	98 КДж	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
38	Хэрэв хүчил шүлт хувцасаар дамжин арьсанд хүрсэн бол ямар арга хэмжээ авах вэ?	3	Эхлээд хувцасыг шарханд хүргэлгүй хайчилж авах ба дараа нь сайтар угаана.	Эхлээд хувцасны химийн бодисыг усаар сайтар угаана, дараа нь хувцасыг тайлж авна.	Эхлээд химийн бодисыг саармагжуулна.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
39	Аюултай хийтэй ажиллахдаа дараахь ямар шаардлагыг хангах ёстой вэ? 1. Нийлэг эдээр хийсэн дотуур хувцас өмсөж болно 2. Зөөврийн гэрэл нь тэсрэлтээс хамгаалагдсан байна 3. Гэрэлтүүлэгийг унтрааж, залгаж болохгүй 4. Ил гал гаргахыг хориглох 5. Оч үүсгэхгүй өнгөт металлаар хийгдсэн багаж хэрэглэх	3	1,2,3	2,3,4,5	1,2,3,4	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
40	Ямар үед уур усны сорьц авахыг хориглох вэ?	3	Уураар үлээсэн үед	Усан цохиотой буюу ууршилттай үед	Усны урсгал тогтвортой болсон зохих температурт хүрсэн үед	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
41	Устөрөгч агаарын эзэлхүүний хэдэн хувийг эзэлвэл дэлбэрэх аюул бүхий хольц үүсгэдэг вэ?	3	5-75%	5-70%	4-75%	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

42	Тоноглолд химийн аргаар цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулах ба гүйцэтгэх, мөн химийн бодистой харьцахад мөрдөх аюулгүй ажиллагааны арга хэмжээний талаар зааварчлага өгөх асуудлыг хэн хариуцах вэ?	3	ХАБЭА-н инженер	Хими хяналтын менежер	Химич	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
43	Орчны агаарын халуун 25С байхад дулааны хучлагын гадаргуу дэрх халуун хэдэн градус байх вэ?	3	35С	40С	45С	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
44	Тохиолдлоор аммиак уусан үед ямар арга хэмжээ авах вэ?	3	Нэг аяга усанд цайны нэг халбага цууны хүчил хийж найруулан 8-10 аягыг уулгаж бөөлжүүлнэ.	Нэг аяга усанд цайны 8-10 халбага цууны хүчил хийж найруулан уулгаж бөөлжүүлнэ.	Нэг аяга усанд цайны нэг халбага цууны хүчил хийж найруулан 3-4 аягыг уулгаж бөөлжүүлнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
45	Цус алдах үед хэдэн цэг дээр дарж цус тогтоож болох вэ?	3	8 цэг	10 цэг	12 цэг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
46	Триллон –Б –н усанд уусах чанар 200С –т хэдэн хувь байдаг вэ?	3	10%	20%	25%	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
47	Химийн тоосрох хуурай бодисыг буулгах шохойг найруулах, химийн бодисуудыг уусгах ажлыг хийж гүйцэтгэхдээ ямар хувцас өмсөх вэ? 1. Ажлын даавуун өмд, цамц 2. Резин хормогч 3. Нүдний шил 4. Брезентэн бээлий 5. Хуруутай резин бээлий 6. Резинэн гутал 7. Тоосноос хамгаалах хошуувч	4	1,2,4,5,6	1,4,5,6	3,4,5,6	Бүгд	Сонголт байхгүй
48	Кальцжуулсан сод ба натрийн фосфат нь химийн ямар шинж чанартай вэ?	3	Кальцжуулсан сод ба натрийн фосфат нь усанд сайн уусдаг цагаан өнгөтэй талст бодис	Хүчиллэг шинж чанартай	Хатуулагийн ионтой нэгддэг учир ангижруулах шинж чанартай	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
49	Сод ба фосфатын тоос нь ямар хортой үйлчилгээ үзүүлдэг вэ	3	Амьсгалын эрхтэнийг түлэх , нүдэнд орвол нүдний салст бүрхүүлийг гэмтээх	Амьсгалын эрхтэнийг үрэвсүүлэх , нүдний салст бүрхүүлийг гэмтээх	Амьсгалын эрхтэн, нүдэнд орвол нүдний салст бүрхүүлийг гэмтээх	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
50	5% -н хольцтой аммиакаар амьсгалахад ямар шинж тэмдэг огцом илэрдэг вэ? 1. Амьсгал боогдох 2. Нүд өвдөж нулимс гоожих 3. Хүчтэй ханиалгах , толгой эргэх 4. Цустай цэр гарах 5. Ходоод өвдөх ба бөөлжих	4	1,2,3	1,2,3,5	3,4,5	Бүгд	Сонголт байхгүй

51	Хүчил юүлэх ажил гүйцэтгэж байгаа хүмүүс ямар хамгаалах хэрэгсэл хэрэглэх вэ? 1. Хүчлээс хамгаалах эдээр хийсэн хувцас 2. Резинжүүлсэн хормогч , резинэн гутал 3. Хүчил шүлтэнд тэсвэртэй резинэн бээлий 4. Нүдний хамгаалах шил буюу органик шилээр хийсэн хаалт болон шүүгч 5. Резинэн хоолойтой хорт угааны баг	4	1,2,3,5	1,2,3,4	3,4,5	Бүгд	Сонголт байхгүй
52	Амьсгалын зам нь аммиакаар хордсон үед ямар арга хэмжээ авах вэ?	3	Цуу, нимбэний хүчлийн хэдэн талстууд хийсэн усны бүлээн уураар амьсгалуулж, бүлээн сүү уулгана.	Цууны хүчлийн хэдэн талстууд хийсэн бүлээн ус уулгаж, дараа нь бүлээн сүү уулгана.	Цуу нимбэний хүчлийн хэдэн талстууд хийсэн усны бүлээн уураар амьсгалуулна.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
53	Лабораторын ажлын өрөөнд шатамхай бодис бүрээс хэдэн кг-аас ихгүй , нийтдээ хэдэн кг –аас ихгүйг хадгалахыг зөвшөөрдөг вэ?	3	Бодис бүрээс 1кг-аас ихгүй, нийтдээ 5кг-аас ихгүй байж болно.	Бодис бүрээс 0,5 кг-аас ихгүй, нийтдээ 4кг-аас ихгүй байж болно.	Бодис бүрээс 1кг-аас ихгүй, нийтдээ 4кг-аас ихгүй байж болно.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
54	Хийтэй баллоныг дулаацуулгын радиатор, бусад халаалтын болон цахилгаан халаагч хэрэгслэлүүдээс хэдэн м-ээс багагүй зайд тавих вэ?	3	1,0 м	1,2 м	1,5м	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
55	Бригадын бүрэлдэхүүнд дадлага хийж байгаа сурагчид, дүрмийн мэдлэгийн шалгалт өгөөгүй ажилчид болон бригадын үндсэн гишүүдийн тооны харьцаа ямар байхыг зөвшөөрдөг вэ?	3	1 ажилчин : 1 дагалдан	2 ажилчин : 1 дагалдан	3 ажилчин : 1 дагалдан	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
56	Химийн цэвэр хүхрийн хүчил ямар шинж чанартай вэ?	3	Өнгөгүй, тосорхог шингэн, агаарт ууршижтай	Өнгөгүй, тосорхог шингэн бодис	Өнгөгүй, тосорхог шингэн, ОС-д талст болж хатуурдаг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
57	Аммиак ямар шинж чанартай вэ? 1. Өнгөгүй 2. Шатдаг хий 3. Онцгой хурц үнэртэй 4. Агаараас хөнгөн 5. Хортой хий	4	1,2,3	2,3,4,5	1,3,4,5	Бүгд	Сонголт байхгүй
58	Идэмхий натрийн уусмал хувцсанд хүрвэл ямар уусмалаар саармагжуулах вэ?	3	Усаар угаах 1%-н цууны хүчлийн уусмалаар саармагжуулж, дахин усаар угаана.	1%-н цууны хүчлийн болон борын хүчлийн уусмалаар саармагжуулж, их хэмжээний усаар сайтар угаана.	3%-н цууны уусмалаар саармагжуулж, их хэмжээний усаар угаана.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
59	Аммиак агаарын эзэлхүүний хэдэн хувийг эзэлвэл дэлбэрэх аюул бүхий хольц үүсгэдэг вэ?	3	12-25%	15-28%	15-20%	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
60	Цахилгаан станцад хэдэн хувийн аммиак агуулсан аммиакийн уусмал хэрэглэдэг вэ?	3	20-25% NH ₃	22-25% NH ₃	20-22% NH ₃	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

61	Аюултай хий бүхий , мөн хортой бодистой харьцаг байранд байгаа тоноглолд үйлчилдэг хүмүүсийн мэдвэл зохих зүйлс: 1.Цехийн аюултай хий бүхий ажлын байрны жагсаалт, 2.Хортой бодисуудын хордуулах үйлчилгээ, хордолтын шинж тэмдэг, 3.Аврах гарц хаалганы байршлыг мэддэг байх, 4.Аюултай хий бүхий ажлын байранд ажил гүйцэтгэх тэнд ажиллах дүрэм, 5.Галын аюултай бодистой харьцах журам, гарсан галыг унтраах аргууд, 6.Хордсон хүмүүсийг аюултай хий бүхий ажлын байрнаас зөөх журам, эмнэлэгийн анхны тусламж үзүүлэх аргууд,	4	1,2,3,4,5	1,2,4,5,6	3,4,5,6	Бүгд	Сонголт байхгүй
62	Бензол ямар хортой нөлөө үзүүлдэг вэ?	3	Эрүүл арьсаар дамжин хүний биед орж мэдрэлийн системд нөлөөлнө.	Эрхтэн ба эрүүл арьсаар дамжин хүний биед орж мэдрэлийн систем болон хорт хавдар үүсэхэд нөлөөлнө.	Эрхтэн ба эрүүл арьсаар дамжин хүний биед орж мэдрэлийн системд нөлөөлнө.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
63	Нүд түлэгдсэн үед ямар арга хэмжээ авах вэ?	3	Усаар сайтар зайлж угаан битүү боох.	Нэг аяга усанд хагас халбага борын хүчил хийсэн уусмалаар хүйтэн жин тавьж эмнэлэгт хурдан хүргэх.	500 гр усанд 3 халбага борын хүчил хийсэн уусмалаар хүйтэн жин тавьж эмнэлэгт хурдан хүргэх.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
64	Бригад нь ажил гүйцэтгэгчийг оролцуулаад хэдээс доошгүй хүний бүрэлдхүүнтэй байх ёстой вэ?	4	2	3	4	5	Сонголт байхгүй
65	Түлэгдэх үед арьс цэврүүлэхийг хэддүгээр зэргийн түлэгдэлтэнд хамруулах вэ?	3	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
66	Суганы хонхор мөрнөөс цус алдвал анхны тусламжийг хэрхэн үзүүлэх вэ?	3	Эгэмний артерийн судсыг эгэмний доод хонхорын ясанд шахаж дарна	Цусыг тогтоож боолт хийнэ	Цээж, мөрөнд марелиар битүү боолт хийж эмнэлэгт хүргэх	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
67	А ангиллын гал түймэр нь ямар бодис, материалын гал түймэр вэ?	3	Шингэн бодис, материалын	Хатуу бодис, материалын	Хийн тала байдалтай бодис, материалын	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
68	16-18 хүртэл насны эрэгтэй хүн 1 дугуйт тэргэнцэрээр хэдэн кг ачаа зөөхийг зөвшөөрөх вэ?	3	49кг	55кг	60кг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
69	Хүзүүний нугалам гэмтсэн байх эрсдэлтэй тохиолдолд амьсгалын замыг ямар аргаар чөлөөлөх вэ?	4	Толгойг гэдийлгэн байрлуулж,эрүүний шонтогоос өргөх	Эрүүний өнцгөөс түлхэж амыг эрхий хуруугаар дарж ангайлгах	Дээрхи хоёр ара хоёулаа зөв	Дээрхи хоёр арга хоёулаа буруу	Сонголт байхгүй
70	Наряд ам шийдвэрийн дууссан журналыг ямар хугацаанд хадгалах вэ?	3	Сүүлийн бүртгэл хийснээс хойш 3 сар	Сүүлийн бүртгэл хийснээс хойш 6 сар	Сүүлийн бүртгэл хийснээс хойш 12 сар	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
71	Цус тогтоох түр зуурын ямар аргууд байдаг вэ?	5	Чангалуур тавих	Тусгай цэг дээр ясанд тултал дарах	Үеэр нь нугалж боох	Даралттай боолт хийх	Бүгд зөв

72	Галын аюулгүй байдлыг хангах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нь хэний үүрэг вэ?	3	Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн үүрэг.	Гал сөнөөгч-аврагч нарын үүрэг.	Хүн болгоны үүрэг.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
73	Шийдвэрээр ажил гүйцэтгэх үед хариуцлагатай удирдагч томилох уу?	3	Томилох эсэхийг наряд, шийдвэр олгогч шийдвэрлэнэ	Томилно	Томилохгүй ажлын шаардлагаас болж цехийн дарга шийдвэрлэнэ	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
74	Түлэгдэлтээс болж ухаан нь балартаж гүй хүндрэлд орсон хүнд анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх вэ?	3	15-20 дусал валерины уусмал уулгах	20-25 дусал валерины уусмал уулгах	Этилийн спирт үнэрлүүлэх	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
75	Насанд хүрээгүй хүмүүсийг хлоржуулах тоноглолын үйлчилгээ хийх ажлыг хийлгэж болох уу?	3	Зөвшөөрнө	Зөвшөөрөхгүй	Зөвхөн хлоржуулаагүй үед	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
76	Наряд гэж юу вэ?	3	Ажлын аюулгүй гүйцэтгэх байр, цаг хугацаа нөхцөл, аюулгүй арга хэмжээнүүд болон бригадын бүрэлдэхүүн, ажлын аюулгүй байдлыг хариуцах хүнийг тодорхойлох бичгэн шийдвэр юм	Ажлыг аюулгүй гүйцэтгэх байр, аюулгүй байх нөхцөл, бригадын хүний тоо, нарядыг хариуцагч хүнийг тодорхойлох бичгэн шийдвэр	Ажлыг аюулгүй гүйцэтгэх бүх нөхцлийг хугацаатай заасан ба ажил гүйцэтгэх бүрэлдэхүүн, ахлагчийг тодорхойлох бичгэн шийдвэр	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
77	Амьсгалын замыг чөлөөлсний дараа та юу хийх вэ?	3	Ажиглах сонсох мэдрэх аргаар амьсгал зогссон эсэхийг тогтооно	Хоёр удаа амьсгалуулна	Цээжний шахалт	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
78	Насанд хүрсэн эмэгтэйчүүд 2 дугуйтай түрдэг тэргэнцэрээр явах зам нь тэгш, налуу нь 0,02м-с ихгүй үед өргөх зөөх ачааны хүндийн дээд хэмжээ хэд байх вэ?	3	105 кг	115 кг	125 кг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
79	Цавь болон ясны уулзвар орчимд өвдөж хөлөө эгц дээш өргөж чадахгүй байгаа нь	3	Нурууны үен завсар зөөлөн эд хавчуулсан	Үе мултарч бэртсэн	Аарцагны ясны хугарал	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
80	Шингэн бодисын гал түймрийг ямар төрлийн гал унтраагуулаар унтрааж болохгүй вэ?	3	Усан гал унтраагуул	Хөөсөн гал унтраагуул	Нунтаган гал унтраагуул	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
81	Насанд хүрсэн эмэгтэй хүн нэг дугуйт тэргэнцэрээр хэдэн кг ачаа зөөхийг зөвшөөрөх вэ?	3	50	80	100	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
82	Цус тогтоох чангалуурыг ямар хугацаанд тавихыг зөвшөөрөх вэ?	3	1.5 цаг	2 цаг	2.5 цаг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
83	Өндөрт ажиллахыг тусгай ажилд тооцох уу?	2	Тооцохгүй	Тооцно	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
84	Ариун цэврийн өрөөг хаана байрлуулахыг хориглох вэ?	3	Хийн шугам хоолойн доор	Үйлдвэрийн заал дотор	Засварын өрөөнд	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
85	Насанд хүрээгүй хүмүүсийг ямар ажил хийхийг хориглох вэ?	3	Зуухны цэвэрлэгээ	Туслах ажилчин	Туслах нярав	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
86	Нарядыг хэдэн удаа сунгахыг зөвшөөрөх вэ?	3	1 удаа	2 удаа	Хэдэн ч удаа байж болно	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
87	Аюулгүй ажиллагааны улаан өнгөтэй тэмдэг юуг анхааруулдаг вэ?	4	Анхааруулах	Заах	Хориглох	Сануулах	Сонголт байхгүй

88	Цахилгаан гүйдэлд нэрвэгдсэн осолдогчийг амьдруулах анхны тусламжийг зүрх зогссоноос хойш хэдэн минутын дотор үзүүлэх вэ?	3	2 минут	3 минут	4 минут	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
89	Түлэгдэх үед арьс цэврүүтэхийг хэддүгээр зэргийн түлэгдэлтэнд хамааруулах вэ?	3	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
90	Анхны тусламж гэж юу вэ?	3	Гэнэтийн осол, хурдан явцтай хүнд өвчин, эмнэлгийн яаралтай туслалцаа шаардсан эрүүл мэнд, амь нас ноцтой аюулд учирсан тохиолдолд эмч ирэхийг хүлээх, өвчтнийг эмнэлэгт хүргэж өгөхөөс өмнө өөрийн хүч бололцоогоо ашиглан үзүүлэх тусламж	Хүний амьд байлгах эмчилгээ	Эмнэлэгт хүргэхээс өмнө үзүүлэх тусламж	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
91	Гал гарах 4 дахь хүчин зүйл аль вэ?	4	Шатах матеирал	Дулааны их үүсвэр	Хүн	Хүчил төрөгч	Сонголт байхгүй
92	Цахилгааны эх үүсвэрт гарсан галыг ямар гал унтраагуураар унтраах нь тохиромжтой бэ?	4	Усан гал унтраагуул	Хөөсөн гал унтраагуул	Нунтаган гал унтраагуул	Нүүрс хүчлийн хийн гал унтраагуур	Сонголт байхгүй
93	Ам шийдвэр ямар хугацаатай өгөгдөх вэ?	3	8 цаг	12 цаг	24 цаг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
94	Наряд олгох нэр бүхий хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хэн батлах вэ?	3	Ерөнхий инженер	Цехийн дарга	Салбарын менежер	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
95	Аюулгүй ажиллагааны цэнхэр өнгөтэй тэмдэг юуг анхааруулдаг вэ?	4	Анхааруулах	Заах	Хориглох	Сануулах	Сонголт байхгүй
96	Хаагдсан нарядуудыг ямар хугацаанд хадгалах вэ?	3	14 хоног	30 хоног	60 хоног	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
97	Анхны тусламжийн эмийн санд хөвөн, марель боолт хэдэн ширхэг байх вэ?	3	1ш	3ш	5ш	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
98	Цахилгааны аюул осол ямар тохиолдолд гарах вэ?	4	Тоног төхөөрмж гэмтэлтэй эсвэл буруу суулгасан	Ажлын байрны орчин аюултай байх	Ажлын аюултай хэвшил	Дээрхи бүгдээс	Сонголт байхгүй
99	Цахилгааны аюулын улмаас хэдэн төрлийн гэмтэл бэртэл шууд хүний биед үүсдэг вэ?	3	3 төрөл	Тооцоолох боломжгүй	4 төрөл	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
100	Эмийн сан байрлуулах газрыг хэн тогтоох вэ?	3	Цехийн захиргаа нь эмнэлгийн салбартай тохиролцсоны үндсэн дээр	Станцын захиргаа эмчийн зааснаар	Эмнэлгийн салбар нь ААБИ-тэй тохиролцсоны үндсэн дээр	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
101	Жижиг төрлийн металлыг хэдэн метрээс өндөргүй хураах вэ?	3	1м	1.2м	1.5м	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
102	16-18 насны эмэгтэй хүн хэдэн кг ачаа гараар өргөхийг зөвшөөрөх вэ?	3	10кг	15 кг	20кг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
103	Ажилагсадаас мэдлэгийн шалгалт авч мэргэжлийн зэрэг олгох ажлыг хэн хийх вэ?	4	Ерөнхий инженерээр ахлуулсан комисс	Сургалтын инженер	БХХ, албадын дарга нарын комисс	Техник ашиглалтын байцаагч инженер, Аюулгүй ажиллагааны байцаагч инженер нарын бүрэлдэхүүнтэй комисс	Сонголт байхгүй

104	Мэргэшилийн хэддүгээр зэрэгтэй ажилчин туслах тоноглолын засварын ажилд, ажил гүйцэтгэгчээр томилогдох эрхтэй вэ?	3	IV зэрэгтэй	III зэрэгтэй	Зөвхөн ИТА нар	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
105	Аюулгүй ажиллагааны ногоон өнгөтэй тэмдэг юуг анхааруулдаг вэ?	4	Анхааруулах	Заах	Хориглох	Сануулах	Сонголт байхгүй
106	Дүүжин шатны хашлагад хаалга хийхийг зөвшөөрөх үү?	2	Зөвшөөрнө	Зөвшөөрөхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
107	Судаснаас цус алдаж байгаа үед цус тогтоохоор тавьсан чангалуурыг хэдэн цагаас илүү тавьж болохгүй вэ?	3	2 цаг	3 цаг	1 цаг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
108	Нөөслөх саван дотор ажиллаж байгаа ажилчин "хэвийн байна" гэсэн дохиог өгөхдөө аврах олсыг хэдэн удаа татах вэ?	3	1	2	3	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
109	Анхны тусламжийн эмийн санд хөвөн боолт хэдэн ширхэг байх вэ?	3	1 ш	3 ш	5 ш	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
110	DRABC – зарчим гэдэг нь:	3	Аюулыг таних, ухаантай эсэхийг шалгах, амьсгалын замыг чөлөөлөх, амьсгалаж бу эсэхийг шалгах, цусны эргэлтийг шалгах	Ухаантай эсэхийг шалгах, Амьсгалын замыг чөлөөлөх, Хажуугийн байрлалд оруулах	Аюулыг таних, ухаантай эсэхийг шалгах, амьсгалын замыг чөлөөлөх, амьсгалаж бу эсэхийг шалгах, Хажуугийн байрлалд оруулах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
111	CPR гэдэг нь:	3	Хиймэл амьсгал хийх	Зүрх судасны сэхээн амьдруулалт	Зүрхний иллэг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
112	Хөлдөх үед арьс цэврүүтэхийг хэддүгээр зэрэгт хамрагдах вэ?	3	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
113	Биеийн температур хэдэх градус хүрэх үед хөлдөлт буюу осголтын шинж илрэх вэ?	3	32C	33C	30C	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
114	Цус алдалтыг хэлбэрээр нь	3	Ил, Далд	Гадуур, Дотуур	Тараагуур, хураагуур	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
115	Гадуур цус алдалт гэдэг нь	3	Хүчтэй доргилт, битүү гэмтлийн улмаас эд эрхтэнүүд гэмтэх эсвэл дотор эрхтэний зарим өвчний хүндрэлээс болж тэнд орших судас гэмтсэнээс биеийн дотуур хөндийд алдаж байгааг	Гадны янз бүрийн хүчин зүйлийн улмаас арьс, салст, тэнд орших цусны судсууд гэмтсэнээс гарч байгаа цус алдалтыг хэлнэ.	Хүчтэй доргилт, битүү гэмтлийн улмаас эд эрхтэнүүд гэмтэх эсвэл дотор эрхтэний зарим өвчний хүндрэлээс болж тэнд орших судас гэмтсэнээс гарч байгаа цус алдалтыг хэлнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
116	Түлэгдэх үед арьс үхжих нь хэддүгээр зэргийн түлэгдэлтэнд хамруулах вэ?	3	1-р зэрэг	2-р зэрэг	3-р зэрэг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

117	Түлэгдсэн үед яаралтай эмнэлэгт хүргэх шаардлагатай тохиолдол : А. Гарын алганаас том хэмжээтэй 2-р зэргийн түлэгдэлт Б.Нүүр болон үен дээр байрласан түлэгдэлт В. Биений аль ч хэсэгт байрласан 3-р зэргийн түлэгдэлт Г. Хөл болон алганы хэмжээтэй 2-р зэргийн түлэгдэлт Д. Бүх түлэгдэлтүүдэд	4	А,Б,В	А,Б,Д	Б,В,Д	Бүх тохиолдолд	Сонголт байхгүй
118	Түлэгдсэн үед хориглох заалтууд нь аль вэ? А. Түлэгдсэн хэсэг дээр цас, мөсийг тавих. Б.Түлэгдсэн хэсгийн арьсан дээр үүссэн цэврүүг хагалах В.Түлэгдсэн хэсэгт наалдсан хувцасыг хуулах Г.Түлэгдсэн хэсэг дээр хөвөн материал тавих	4	А,Б,В	А,Б,В	Б,В,Д	Бүгд	Сонголт байхгүй
119	Дотуур цус алдалт гэдэг нь	3	Хүчтэй доргилт, битүү гэмтлийн улмаас эд эрхтэнүүд гэмтэх эсвэл дотор эрхтэний зарим өвчний хүндрэлээс болж тэнд орших судас гэмтсэнээс биений дотуур хөндийд алдаж байгааг	Гадны янз бүрийн хүчин зүйлийн улмаас арьс, салст, тэнд орших цусны судсууд гэмтсэнээс гарч байгаа цус алдалтыг хэлнэ.	Хүчтэй доргилт, битүү гэмтлийн улмаас эд эрхтэнүүд гэмтэх эсвэл дотор эрхтэний зарим өвчний хүндрэлээс болж тэнд орших судас гэмтсэнээс гарч байгаа цус алдалтыг хэлнэ.	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
120	Осголт гэдэг нь	2	Нам температурын улмаас хэсэг газрын арьс, улмаар эд эрхтэнүүдийн цусан хангамж алдагдаж хүйтэнд хайрагдсан арьсны бүтэц өөрчлөгддөг. Ихэвчлэн биений захын хэсгүүд болох гар хөлийн хуруунууд, чих, хамар, хацар, эрүү зэрэг хөлдөхийг	Хүйтэн, нойтон, салхи, шуургатай газар удаан хугацаагаар байснаас биений дулаан буурч, бүх эрхтэн системийн талаас өөрчлөлт гарч хөлдөхийг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
121	3-р зэргийн түлэгдэлтийн үед арьс салстанд ямар гэмтэл учрах вэ?	3	Арьсны өнгөц, жинхэнэ арьс гэмтэнэ	Арьсны бүх давхарга гэмтэнэ	Арьсны өнгөц давхарга гэмтэнэ	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
122	Ухаангүй хүний амьсгалыг шалгаж үзээд амьсгалаж байвал та ямар тусламж үеүүлэх вэ?	3	Зүрхний шахалт хийх 30 удаа даралт, 2 удаа амьсгал	Хиймэл амьсгал хийх 30 удаа даралт, 2 удаа амьсгал	Хажуугийн байрлалд оруулах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй

123	Анхны тусламжийн ач холбогдол нь юу вэ? А. Осолд өртөгсдийн амь насыг аварна. Б. Эдгэрэлтийг түргэсгэнэ. В. Хүндрэлээс сэргийлнэ. Г. Хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулна. Д. Эмчилгээний зардлыг багасгана	4	А,Б,В	А,Б,В	Б,В,Д	Бүгд	Сонголт байхгүй
124	Яаралтай анхны тусламж гэдэг нь:	4	Гэнэтийн осол, хурдан явцтай хүнд өвчин, эмнэлгийн яаралтай туслалцаа шаардсан эрүүл мэнд, амь нас ноцтой аюулд учирсан тохиолдолд эмч ирэхийг хүлээх, өвчнийг эмнэлэгт хүргэж өгөхөөс өмнө өөрийн хүч бололцоогоо ашиглан үзүүлэх тусламж.	Ямар нэгэн амь насанд аюул заналхийлсэн, ноцтой осол гэмтлийн үед хүний амийг аврах зорилгоор нэн даруй авч буй арга хэмжээг хэлнэ.	Хүний амьд байлгах эмчилгээ	Эмнэлэгт хүргэхээс өмнө үзүүлэх тусламж	Сонголт байхгүй
125	Хөлдөлт гэдэг нь	2	Нам температурын улмаас хэсэг газрын арьс, улмаар эд эрхтнүүдийн цусан хангамж алдагдаж хүйтэнд хайрагдсан арьсны бүтэц өөрчлөгддөг. Ихэвчлэн биеийн захын хэсгүүд болох гар хөлийн хуруунууд, чих, хамар, хашар, эрүү зэрэг хөлдөхийг	Хүйтэн, нойтон, салхи, шуургатай газар удаан хугацаагаар байснаас биеийн дулаан буурч, бүх эрхтэн системийн талаас өөрчлөлт гарч хөлдөхийг	Сонголт байхгүй	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
126	Гадны зүйлийг авсны дараа шарханд юу түрхэж боох вэ?	3	Вазелин	Тос	Иодын уусмал	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
127	Гадны зүйл ороход нүдийг яаж болохгүй вэ?	3	Нүдээ нээж	Нухаж	Хөвөнгөөр дарах	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
128	Цахилгаанд нэрвэгдсэн хүнд юу хамгийн чухал вэ?	4	Анхны тусламж	103 эмнэлэгийн тусламж	Цахилгаанаас хурдан хугацаанд салгах	Дээрх бүгд	Сонголт байхгүй
129	Хордлогын бүх тохиолдолд яаралтай ямар арга хэмжээ авах вэ?	3	Хордсон бүсээс гаргана	Хиймэл амьсгал хийнэ	Ходоодыг яаралтай угаана	Сонголт байхгүй	Сонголт байхгүй
Нийт				129			